

# Garcinia cambogia агуулсан бүтээгдэхүүний талаарх сэрэмжлүүлэг

Гарцини камбоджи (Garcinia cambogia) эсвэл Гидроксицитратын хүчил агуулсан эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн нь ховор тохиолдолд элэг гэмтээх эрсдэлтэй болохыг Австралийн эмийн зохицуулах хорооноос албан ёсоор мэдээлсэн байна.

Эх үүсвэр: [https://www.tga.gov.au/news/safety-alerts/medicines-containing-garcinia-gummi-gutta-garcinia-cambogia-or-hydroxycitric-acidhca?fbclid=IwY2xjawFGDepleHRuA2FlbQlxMAABHc0FTsgO91QBqWIIJ65NR3fVSOtqxYbndnLBZFJER\\_zKR6nJEfznqTLILQ\\_aem\\_WVjFzeKtoakYYgJHfdbBwQ](https://www.tga.gov.au/news/safety-alerts/medicines-containing-garcinia-gummi-gutta-garcinia-cambogia-or-hydroxycitric-acidhca?fbclid=IwY2xjawFGDepleHRuA2FlbQlxMAABHc0FTsgO91QBqWIIJ65NR3fVSOtqxYbndnLBZFJER_zKR6nJEfznqTLILQ_aem_WVjFzeKtoakYYgJHfdbBwQ)

Энэхүү эрсдэл нь Гидроксицитратыг найрлагандаа агуулсан бүх бүтээгдэхүүнд хамраалтай. Үүнд: Garcinia quaesita, Гидроксицитратын нэгдэл, Кальцийн гидроксицитрат, Натри эсвэл Калийн гидроксицитрат багтана.

Гарцини камбоджи нь ихэвчлэн тураах бүтээгдэхүүн, мэргэжлийн тамирчид, бялдаржуулах урлагаар хичээллэж буй тамирчдын хэрэглэдэг бүтээгдэхүүнд агуулагддаг байна.


Монгол улсын эмийн цахим бүртгэлд албан ёсоор бүртгэгдсэн Гарцини камбоджи агуулсан 9 нэр төрлийн бүтээгдэхүүн байдаг.



**Гарцини камбоджи** агуулсан эдгээр бүтээгдэхүүнийг хэрэглэх үед доорх шинж тэмдгүүд илэрвэл бүтээгдэхүүнийг хэрэглэхээ даруй зогсоож, эмчид хандана уу.

Үүнд:

- Арьс, нүд шарлах
- Шээс бараан өнгөтэй болох
- Дотор муухайрах
- Бөөлжих
- Амархан ядарч сульдах
- Бие сулрах
- Хэвлийгээр өвдөх
- Хоолны дуршилгүй буурах гэх мэт.



Хэрэв элэгний хурц болон архаг хууч өвчтэй бол Гарцинигийн найрлага бүхий бүтээгдэхүүн хэрэглэхээс зайлсхийх шаардлагатайг сэрэмжлүүлж байна.

Эх үүсвэр:

[http://www.druginfo.mohs.mn/#ViewID=UDB\\_DISPProductBiologicalActive\\_ListView&ObjectClassName=UIS.UDB\\_DISPProductBiologicalActive](http://www.druginfo.mohs.mn/#ViewID=UDB_DISPProductBiologicalActive_ListView&ObjectClassName=UIS.UDB_DISPProductBiologicalActive)

---

Монгол улсын эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлд бүртгэгдээгүй, орц найрлага нь тодорхой биш, хадгалалт түгээлт, тээвэрлэлтийн горим нь алдагдсан, чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй, хуурамч байж болзошгүй бүтээгдэхүүн худалдан авч, хэрэглэхээс **ТА ТАТГАЛЗАХ БҮРЭН ЭРХТЭЙ**.

Эх үүсвэр: [https://www.tga.gov.au/news/safety-alerts/medicines-containing-garcinia-gummi-gutta-garcinia-cambogia-or-hydroxycitric-acidhca?fbclid=IwY2xjawFGDepleHRuA2FlbQlxMAABHc0FTsgO91QBqWIIJ65NR3fVSOtqxYbndnLBZFJER\\_zKR6nJEfznqTLILQ\\_aem\\_WVjFzeKtoakYYgJHfdbBwQ](https://www.tga.gov.au/news/safety-alerts/medicines-containing-garcinia-gummi-gutta-garcinia-cambogia-or-hydroxycitric-acidhca?fbclid=IwY2xjawFGDepleHRuA2FlbQlxMAABHc0FTsgO91QBqWIIJ65NR3fVSOtqxYbndnLBZFJER_zKR6nJEfznqTLILQ_aem_WVjFzeKtoakYYgJHfdbBwQ)

## Анхааруулга:

Таны хэрэглэж буй бүтээгдэхүүн дээрх зурагт байхгүй бол та Монгол улсад албан ёсны бүртгэлгүй, чанаргүй, хуурамч байх магадлалтай бүтээгдэхүүн хэрэглэж байж болзошгүй юм.

ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ГАЗАР

2024 ОН